



IFRS[®]

Sustainability

2025 оны 4 дүгээр сар

Саналын Төсөл

IFRS[®] Sustainability Disclosure Standard

СТОУС Тогтвортой Байдлын Тодруулгын Стандарт

Хүлэмжийн Хийн Ялгаруулалтын Тодруулгад Оруулах Нэмэлт Өөрчлөлт

СТОУС ТБ2-т оруулахаар санал болгож буй нэмэлт
өөрчлөлт

Саналыг 2025 оны 6 дугаар сарын 27-ны дотор хүлээн авна.

**Exposure Draft
Amendments to Greenhouse Gas
Emissions Disclosures**

Proposed amendments to IFRS S2

Comments to be received by 27 June 2025

Exposure Draft ISSB/ED/2025/1 is published by the International Sustainability Standards Board (ISSB) for comment only. Comments need to be received by **27 June 2025** and should be submitted by email to commentletters@ifrs.org or online at <https://www.ifrs.org/projects/open-for-comment/>.

All comments will be on the public record and posted on our website at www.ifrs.org unless the respondent requests confidentiality. Such requests will not normally be granted unless supported by a good reason, for example, commercial confidentiality. Please see our website for details on this policy and on how we use your personal data.

Disclaimer: To the extent permitted by applicable law, the ISSB and the Foundation expressly disclaim all liability howsoever arising from this publication or any translation thereof whether in contract, tort or otherwise to any person in respect of any claims or losses of any nature including direct, indirect, incidental or consequential loss, punitive damages, penalties or costs.

Information contained in this publication does not constitute advice and should not be substituted for the services of an appropriately qualified professional.

© 2025 IFRS Foundation

All rights reserved. Reproduction and use rights are strictly limited. Please contact the Foundation for further details at permissions@ifrs.org.

Copies of ISSB publications may be ordered from the Foundation by emailing customerservices@ifrs.org or by visiting our shop at <https://shop.ifrs.org>.

The Mongolian translation of the Exposure Draft contained in this publication has not been approved by a review committee appointed by the IFRS Foundation. The Mongolian translation is copyright of the IFRS Foundation.



The IFRS Foundation has trade marks registered around the world including 'FSA®', the 'Hexagon Device' logo®, 'IAS®', 'IASB®', 'IFRIC®', 'IFRS®', the 'IFRS®' logo, 'IFRS for SMEs®', 'ISSB®', 'International Accounting Standards®', 'International Financial Reporting Standards®', 'International Financial Reporting Standards Foundation®', 'IFRS Foundation®', 'NIIF®', 'SASB®', 'SIC®', 'SICS®', and 'Sustainable Industry Classification System®'. Further details of the IFRS Foundation's trade marks are available from the IFRS Foundation on request.

The Foundation is a not-for-profit corporation under the General Corporation Law of the State of Delaware, USA and operates in England and Wales as an overseas company (Company number: FC023235) with its principal office in the Columbus Building, 7 Westferry Circus, Canary Wharf, London, E14 4HD.

Саналын Төсөл

Хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгад оруулах

нэмэлт өөрчлөлтүүд

СТОУС ТБ2-т оруулахаар санал болгож буй нэмэлт өөрчлөлт

Саналыг 2025 оны 6 дугаар сарын 27-ны дотор хүлээн авна.

Саналын Төсөл ISSB/ED/2025/1-ийг Тогтвортой Байдлын Олон Улсын Стандартын Зөвлөл (ТБОУСЗ)-өөс хэвлэн нийтлүүлж байгаа бөгөөд уг саналын төсөлд **2025 оны 6-р сарын 27-ны дотор** commentletters@ifrs.org хаягаар саналаа бичгээр хүргүүлэх юм.

Санал ирүүлсэн этгээд саналаа нууцлахыг хүссэнээс бусад тохиолдолд бид ирүүлсэн санал бүрийг олон нийтийн бүртгэлд хадгалж, www.ifrs.org цахим хуудаст нийтэлнэ. Нууцлах хүсэлт нь, жишээлбэл, худалдааны нууцлалтай холбоотой байх тохиолдолд хүсэлтийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү бодлого болон таны хувийн мэдээллийг бид хэрхэн ашиглах тухай манай цахим хуудаснаас дэлгэрүүлэн харна уу.

Мэдэгдэл: Холбогдох хуулиар зөвшөөрсөн тохиолдолд ТБОУСЗ болон Сан нь энэхүү хэвлэл буюу түүний аливаа орчуулгын улмаас гэрээ, иргэний эрхийн зөрчил болон бусад хэлбэрээр хэн нэгэнд учирсан аливаа хохирлын нэхэмжлэл эсвэл шууд, шууд бус, санамсаргүй буюу үр дагаврын гарз гэх мэт аливаа шинж төрөл бүхий гарз, хүлээсэн шийтгэл, торгууль, зардлын хувьд үүсэх хариуцлагыг хүлээхгүй гэдгээ албан ёсоор мэдэгдэж байна.

Энэ хэвлэлд тусгагдсан мэдээллийг зөвлөгөө гэж үзэхгүй бөгөөд зохих шаардлага хангасан мэргэжилтний үзүүлдэг үйлчилгээг төлөөлөн орлохгүй.

© 2025 IFRS Foundation

Бүх эрх хамгаалагдсан. Дахин хэвлэх болон ашиглах эрхийг хатуу хязгаарладаг. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах бол Сангийн sustainability_licensing@ifrs.org хаягаар холбогдоно уу.

ТБОУСЗ-өөс хэвлэн нийтлүүлдэг бүтээгдэхүүнийг customerservices@ifrs.org хаягаар имэйл илгээх эсвэл <https://shop.ifrs.org> цахим дэлгүүрээр зочилж захиалах боломжтой.

Энэхүү хэвлэлд орсон Саналын Төслийн Монгол хэл дээрх орчуулгыг СТОУС Сангаас томилогдсон хяналтын хороо батлаагүй болно. Монгол хэл дээрх орчуулга нь СТОУС зохиогчийн эрхэд хамаарна.



Сан нь дэлхий дахинд бүртгэгдсэн 'FSA®', the 'Hexagon Device' logo®, 'IAS®', 'IASB®', 'IFRIC®', 'IFRS®', the 'IFRS®' гэсэн лого, 'IFRS for SMEs®', 'ISSB®', 'International Accounting Standards®', 'International Financial Reporting Standards®', 'International Financial Reporting Standards Foundation®', 'IFRS Foundation®', 'NIIF®', 'SASB®', 'SIC®', 'SICS®', and 'Sustainable Industry Classification System®' гэсэн худалдааны тэмдэгтэй. Сангийн Худалдааны тэмдгийн талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг Санд хүсэлт гаргаснаар авч болно.

Сан нь АНУ-ын Делавер мужийн Корпорацийн Ерөнхий хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ашгийн төлөө бус корпораци бөгөөд Columbus Building, 7 Westferry Circus, Canary Wharf, London, E14 4HD гэсэн албан ёсны хаягаар бүртгэгдсэн гадаадын компани (Компанийн дугаар: FC023235) байдлаар Англи ба Уэйлсэд үйл ажиллагаагаа явуулдаг.

АГУУЛГА

Хуудасны дугаар

ТАНИЛЦУУЛГА	6
САНАЛ ИРҮҮЛЭХ УРИЛГА	9
[ТӨСӨЛ] СТОУС ТБ2 УУР АМЬСГАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОДРУУЛГАД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ	14
2025 ОНЫ 4-Р САРД ХЭВЛҮҮЛСЭН ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТЫН ТОДРУУЛГАД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН САНАЛЫН ТӨСЛИЙГ ТБОУСЗ-ӨӨС БАТАЛСАН НЬ	24
ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРУУЛАЛТЫН ТОДРУУЛГАД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН САНАЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ (тусдаа товхимолоос харна уу)	

ТБОУСЗ юу төлөвлөж байна вэ?

- T1 Тогтвортой байдлын олон улсын стандартын зөвлөл (ТБОУСЗ) -өөс хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэрхэн тодруулах тухай шаардлагаас чөлөөлөх нэмэлт нөхцөл, мөн одоо байгаа чөлөөлөх заалтыг илүү тодорхой болгох нэмэлт өөрчлөлтийг **СТОУС ТБ2 “Уур амьсгалтай холбоотой тодруулга”**-д оруулах саналын төсөл боловсруулаад байна.
- T2 Ялангуяа, СТОУС ТБ2 дахь дараах асуудалтай холбоотой шаардлагуудыг өөрчлөхөөр ТБОУСЗ төлөвлөж байгаа юм. Үүнд:
- (a) **Хамрах хүрээ 3, Ангилал 15 дахь** үүсмэл хэрэглүүр болон хөрөнгө оруулалтын банкинд хамаарах санхүүгийн тусгай үйл ажиллагаатай холбоотой (хялбаршуулсан ялгаруулалт) ба даатгал, давхар даатгалын андеррайтинг үйл ажиллагаатай холбоотой (даатгалтай холбоотой ялгаруулалт) **хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулга;**
 - (б) санхүүжүүлсэн ялгаруулалтын тухай мэдээллийн тодруулгатай холбоотой тусгай шаардлагыг мөрдөхдөө Дэлхийн Салбарын Ангиллын Стандартыг ашиглах;
 - (в) хэрэв эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь уг аж ахуйн нэгжийн зарим хэсгээс хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжихдээ өөр арга хэрэглэхийг шаарддаг бол Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-аас өөр аргыг хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжихдээ ашиглах
 - (г) хэрэв эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь *Уур Амьсгалын Өөрчлөлтийн* Асуудлаарх Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Зөвлөлөөс 100 жилийн хугацааны хүрээнд үндэслэн хамгийн сүүлд гаргасан, тухайн тайлагналын өдөр хэрэглэх боломжтой байгаа (дэлхийн дулаарлын потенциал ДДП) үнэ цэнээс өөр ДДП үнэ цэнэ ашиглахыг шаарддаг бол тэрхүү ДДП үнэ цэнийг ашиглах.

ТБОУСЗ яагаад энэ Саналын төслийг хэвлэн гаргаж байгаа вэ?

- T3 СТОУС ТБ1, *Тогтвортой байдалд хамаарах санхүүгийн мэдээллийн тодруулгын ерөнхий шаардлагууд* ба СТОУС ТБ2-ын хэрэгжилтийг дэмжих нь ТБОУСЗ-ийн ажлын төлөвлөгөөний хамгийн чухал зорилт юм.¹ ТБОУСЗ нь стандартуудыг хэрэгжүүлэхийг дэмжих зорилгоор олон төрлийн үйл ажиллагаа, үүнд сургалтын материал боловсруулах, чадавхийг сайжруулах янз бүрийн санаачлагыг дэмжих зэрэг ажил багтдаг.² Мөн СТОУС ТБ1 ба СТОУС ТБ2-оор Шилжилтийг Хэрэгжүүлэх Бүлэг (ШХБ) байгуулж, хэрэгжилтийн асуудлыг оролцогч талуудтай нээлттэй хэлэлцэх боломжийг бүрдүүлсэн.³
- T4 ТБОУСЗ нь ШХБ-т оролцогч талуудаас ирүүлсэн асуулт болон ТБОУСЗ-ийн бусад үйл ажиллагаа, тухайлбал улс орнуудтай хамтран СТОУС Тогтвортой байдлын тодруулгын стандартуудыг нэвтрүүлэх эсвэл ашиглахтай холбоотой үйл ажиллагаагаар дамжуулан мөрдөхөд тулгарч байгаа сорил бэрхшээлийг авч үзсэн. Зөвлөлийн ажилтнууд СТОУС ТБ2-ыг хэрэгжүүлэх үе шатанд түүнийг мөрдөхөд

¹ *Хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлүүдээр зөвлөлдсөн тухай тайланг* ... холбоосоор орж үзнэ үү.

² СТОУС ТБ1 ба СТОУС ТБ2-ын хэрэгжилтэд дэмжлэг болох сургалтын материалыг ... холбоосоор орж үзнэ үү.

³ СТОУС ТБ1 ба СТОУС ТБ2-ын Шилжилтийг Хэрэгжүүлэх Бүлгийн уулзалтыг нийтэд зориулан тавьсан. Бүх уулзалтын бичлэг, хөтөлбөр болон уулзалтын хураангуйг ... холбоосоор орж үзнэ үү.

тулгарч байгаа сорилтуудын талаар ТБОУСЗ-д мэдэгдэн, эдгээр сорилт нь нэмэлт арга хэмжээ авахыг анхааруулж байгаа эсэхийг судалж үзэхийг хүссэн. ТБОУСЗ- д хандан мэдэгдсэн сорилтууд нь СТОУС ТБ-2-ын саналын төслийг өмнө нь дахин хэлэлцэх үед онцгойлон авч үзээгүй мэдээллээр тэднийг хангасан болно.

T5 Мөрдөхөд тулгарч байгаа тэдгээр сорилтын хариу арга хэмжээ болгон СТОУС ТБ 2-т нэмэлт өөрчлөлт оруулахаар ТБОУСЗ шийдсэн. ТБОУСЗ-ийн санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь уг стандартын тодорхой шаардлагуудыг мөрдөх үед нарийн төвөгтэй байдал, тайлагналын давхардал үүсэх эрсдэл болон зардлыг бууруулах замаар СТОУС ТБ2-ыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг болно гэсэн хүлээлт байгаа. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд хүргэх тогтвортой байдалтай холбоотой санхүүгийн мэдээллийн ач холбогдлыг бууруулахгүй хэмээн үзэж байгаа.

T6 Нэмэлт өөрчлөлт оруулахаар ТБОУСЗ шийдэхдээ, эдгээр нэмэлт өөрчлөлт нь СТОУС ТБ2 дахь хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулах зарим тодорхой шаардлагад нэмэлт чөлөөлөх нөхцөл болон одоо байгаа чөлөөлөх нөхцөлийг илүү тодорхой болгоно гэдгийг тэмдэглэж байгаа. Мөн ТБОУСЗ нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг оруулснаар стандартын хэрэгжилтэд тасалдал гарахгүй, яагаад гэвэл санал болгож буй бүх нэмэлт өөрчлөлт нь сонголтоор хэрэгжүүлэх чөлөөлөх нөхцөлтэй холбоотой эсвэл тийм боломж үүсгэж байгаа бөгөөд үүнийг дараах байдлаар төлөвлөсөн:

- (a) Аж ахуйн нэгжүүд эдгээр чөлөөлөх нөхцөлийг мөрдөх эсэхээ сонгох боломжтой, энэ нь тэдний СТОУС Тогтвортой байдлын тодруулгын стандартад нийцүүлэх байдалд нөлөөлөхгүй;
- (б) Улс орнууд эдгээр чөлөөлөх нөхцөлийг өөр өөрийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгжүүдэд олгох эсэхээ сонгох боломжтой бөгөөд энэ нь тэдгээр улс орон СТОУС Тогтвортой байдлын тодруулгын стандартад хэр нийцүүлдэг байдалд нөлөөлөхгүй.

Санал болгож буй нэмэлт өөрчлөлт хэнд нөлөөлөхөөр байна вэ?

T7 Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулснаар нийтлэг зорилготой санхүүгийн тайлангийн хэрэглэгчид тухайн аж ахуйн нэгжийн уур амьсгалтай холбоотой эрсдэлд өртөлт ба боломжийг үнэлэхэд нь тус болохуйц мэдээллээр хангадаг. Санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь хүлэмжийн хийн ялгаруулалтын мэдээллийг тодруулах шаардлагатай холбоотой бөгөөд СТОУС ТБ2-ыг хэрэгжүүлж буй аж ахуйн нэгжүүдэд өргөн хэрэглэгдэх боломжтой юм. Санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь аж ахуйн нэгжүүдэд харилцан адилгүй нөлөөлөх магадлалтай. Тухайлбал:

- (a) Санхүүгийн салбарын аж ахуйн нэгжүүдэд бусад аж ахуйн нэгжийг бодвол Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулах шаардлагатай холбоотой уг нэмэлт өөрчлөлт илүү ихээр нөлөөлөх магадлалтай;
- (б) ДДП-ын тусгай үнэ цэнэ эсвэл хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжих тусгай өөр арга ашиглахтай холбоотой тухайлсан улс орны шаардлагыг мөрддөг аж ахуйн нэгжүүдэд чөлөөлөх нөхцөлтэй холбоотой санал болгож буй нэмэлт өөрчлөлт бусад аж ахуйн нэгжийг бодвол илүү их нөлөөлөх магадлалтай.

Санал болгож буй нэмэлт өөрчлөлтийг хүчинтэй мөрдөх хугацаа хэзээ эхлэх вэ?

T8 Санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь СТОУС ТБ2-ыг хэрэгжүүлэх ажлыг хялбаршуулахад ахуйн нэгжүүдэд туслах болно. ТБОУСЗ нь эдгээр нэмэлт чөлөөлөх нөхцөл ба одоо байгаа чөлөөлөх нөхцөлийг илүү тодорхой болгох боломжийг аль болох ойрын хугацаанд аж ахуйн нэгжүүдэд олгохыг зорьж байгаа. Иймээс нэмэлт

өөрчлөлтийг хүчинтэй мөрдөх хугацааг аль болох эрт тогтоохоос гадна заасан хугацаанаас өмнөх мөрдөхийг сайшаан дэмжихээр саналыг боловсруулсан.

Дараагийн алхам

- T9 ТБОУСЗ нь Саналын Төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийж, цаашид хэрхэхээ шийднэ. Оролцогч талуудаас ирүүлэх саналыг үндэслэн, 2025 оны 2-р хагас гэхэд Саналын Төсөл дэх нэмэлт өөрчлөлтүүдийг дахин нягталж хэлэлцэхээр ТБОУСЗ төлөвлөж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлтийг аль болох шуурхай гаргахыг зорьж байгаа.

Санал ирүүлэх урилга

ТБОУСЗ нь Саналын Төсөл, ялангуяа дор дурдсан асуулгад саналаа ирүүлэхийг урьж байна. Санал нь дараах нөхцлүүдийг хангасан тохиолдолд илүү ач холбогдолтой байх юм. Үүнд:

- (а) дурдсан асуултыг оруулах;
- (б) Саналын Төслийн хэддүгээр параграфт тухайн санал хамааралтай болохыг заах;
- (в) тодорхой үндэслэл агуулсан байх;
- (г) саналд тусгагдсан ойлгомжгүй, эсвэл орчуулахад хүндрэлтэй үг хэллэгийг олж тодорхойлох;
- (д) боломжтой гэж үзвэл, ТБОУСЗ-ийн харгалзаж болох өөр сонголтот хувилбарыг тусгах.

Хариу ирүүлэх хүмүүст тавих асуулт

Асуулт 1-Хамрах хүрээ 3, Ангилал 15 дахь хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулга

Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгаа хязгаарлах (цөөлөх)-ыг аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөх саналыг Зөвлөл тусгасан. Ингэснээр СТОУС ТБ2-ын 29(а)(i)(3) параграфын дагуу Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжиж, тодруулахдаа Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн зарим ялгаруулалт, үүнд үүсмэл хэрэглүүр, хялбаршуулсан ялгаруулалт болон даатгалтай холбоотой ялгаруулалтыг хасаж тодруулахыг аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөхөөр байгаа.

- (а) ТБОУСЗ-ийн санал: 29А(а) параграфыг нэмж оруулах, ингэснээр Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгыг СТОУС ТБ2-т заасан санхүүжүүлсэн ялгаруулалт (санхүүжигчид буюу оролцогч нөгөө талд аж ахуйн нэгжийн олгосон зээл ба оруулсан хөрөнгө оруулалтад хамаарах хүлэмжийн хийн ялгаруулалт)-аар хязгаарлахыг аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрөх юм. Ийм хязгаарлалтын зорилгоор санал болгож байгаа 29А(а) параграфт, үүсмэл хэрэглүүртэй холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулахгүй байх боломжийг аж ахуйн нэгжүүдэд илэрхий ойлгомжтой зөвшөөрч байгаа. Өөрөөр хэлбэл, уг параграфын дагуу аж ахуйн нэгжүүд үүсмэл хэрэглүүртэй холбоотой ялгаруулалт, хялбаршуулсан ялгаруулалт болон даатгалтай холбоотой ялгаруулалтыг Хамрах хүрээ 3 дахь хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгад оруулахгүй байх боломжтой.

Санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь үүсмэл хэрэглүүртэй холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалт, хялбаршуулсан ялгаруулалт эсвэл даатгалтай холбоотой ялгаруулалтыг тодруулах сонголтыг хийх нь зүйтэй гэж үзсэн аж ахуйн нэгжид ийнхүү тодруулахад нь саад болохгүй.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ7–ДҮ24 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

- (б) ТБОУСЗ-ийн санал: 29А(б) параграфыг нэмж оруулах, ингэснээр дээрх 29А(а) параграфын дагуу Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгаа хязгаарласан аж ахуйн нэгжээс, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчид тухайн аж ахуйн нэгжийн тодруулаагүй орхисон Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалттай холбоотой үүсмэл хэрэглүүр болон санхүүгийн үйл ажиллагааны хэмжээг ойлгохуйц мэдээллээр хангахыг шаардаж байгаа. Тиймээс ТБОУСЗ уг параграфыг дараах байдлаар нэмж оруулах саналыг тусгасан:

Асуулт 1-Хамрах хүрээ 3, Ангилал 15 дахь хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулга

- 29A(б)(i) параграфт, Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулгад үүсмэл хэрэглүүрийг хассан аж ахуйн нэгжээс ийнхүү хассан үүсмэл хэрэглүүрийн дүнг тодруулахыг шаардах;
- 29A(б)(ii) параграфт, Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулгад санхүүгийн үйл ажиллагааг хассан аж ахуйн нэгжээс ийнхүү хассан санхүүгийн бусад үйл ажиллагааны дүнг тодруулахыг шаардах.

‘Үүсмэл хэрэглүүр’ гэдэг нэр томъёог СТОУС Тогтвортой Байдлын Тодруулгын Стандартуудад тодорхойлоогүй бөгөөд ТБОУСЗ энэ нэр томъёог тодорхойлох саналыг ч мөн тусгаагүй. Иймээс, Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгаа хязгаарлах зорилгын хувьд, санал болгож буй 29A(a) параграфын дагуу юуг үүсмэл хэрэглүүр гэж тодорхойлохдоо шүүн тунгаалт хийхийг аж ахуйн нэгжээс шаардаж байгаа. Санал болгож буй 29A(б)(i) параграфт, Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилт ба тодруулгад үүсмэл хэрэглүүрийг хассан аж ахуйн нэгжээс яагаад үүсмэл хэрэглүүрийг хассан тухай тайлбарлахыг шаардаж байгаа.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ7–ДҮ24 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

Асуулт 2- Санхүүжүүлсэн ялгаруулалттай холбоотой тусгай шаардлагуудыг мөрдөхдөө Салбарын Ангиллын Дэлхийн Стандартыг ашиглах

СТОУС ТБ2-ын 29(a)(vi)(2) болон Б62–Б63 параграфт, арилжааны банк эсвэл даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдээс санхүүжүүлсэн ялгаруулалттай холбоотой нэмэлт мэдээллээ тодруулахыг шаарддаг. СТОУС ТБ2-ын В62(a)(i) болон В63(a)(i) параграфын дагуу санхүүжүүлсэн ялгаруулалтын мэдээллээ салган задлахдаа оролцогч нөгөө талуудаа ангилахын тулд Салбарын Ангиллын Дэлхийн Стандарт (САДС) ашиглахыг эдгээр аж ахуйн нэгжээс шаарддаг.

- (a) Зарим нөхцөлд САДС ашиглахаас аж ахуйн нэгжийг чөлөөлөх зорилгоор СТОУС ТБ2-ын В62(a)(i), В63(a)(i) параграф дахь шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулах, В62А–В62Б болон В63А–В63Б параграфыг шинээр нэмж оруулахыг ТБОУСЗ санал болгосон. Энэ саналд зааснаар, СТОУС ТБ2-ын В62(a)–В62(б) болон В63(a)–В63(б) параграфын дагуу тодруулсан, санхүүжүүлсэн ялгаруулалтын мэдээллээ салган задлахдаа аж ахуйн нэгж зарим тохиолдолд ижил төстэй салбарын ангиллын системийг ашиглаж болно.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ25–ДҮ38 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

- (б) ТБОУСЗ мөн В62В, В63В параграфыг шинээр нэмсэн бөгөөд хэрэв аж ахуйн нэгж санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтын мэдээллийг салган задлахдаа САДС-ыг биш харин салбарын ангиллын системийг ашигласан бол уг системийг тодруулж, ямар үндэслэлээр салбарын ангиллын системийг сонгосноо тайлбарлахыг уг аж ахуй нэгжээс шаардаж байгаа.

Асуулт 2- Санхүүжүүлсэн ялгаруулалттай холбоотой тусгай шаардлагуудыг мөрдөхдөө Салбарын Ангиллын Дэлхийн Стандарыг ашиглах

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ25–ДҮ38 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

Асуулт 3-Хүлэмжийн Хийн Протокол Корпорацийн Стандартыг ашиглахаас чөлөөлөх тухай улс орнуудын шаардлага

Хэрэв аж ахуйн нэгж нь өөрийнхөө байгууллагын тодорхой хэсгийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжихдээ "Хүлэмжийн хийн протокол: Корпорацийн нягтлан бодох бүртгэл ба тайлагналын стандарт (2004)"-аас өөр арга ашиглахыг хууль эрх зүйн орчин дахь эрх бүхий байгууллага эсвэл аж ахуйн нэгжийн бүртгэлтэй хөрөнгийн биржээс шаарддаг бол, тухайн хууль эрх зүйн орчин дахь чөлөөлөлтийн цар хүрээг тодорхой болгох зорилгоор ТБОУСЗ-өөс СТОУС ТБ-2ын 29(а)(ii) болон Б24 параграфт нэмэлт өөрчлөлт оруулж байгаа.

Уг нэмэлт өөрчлөлтөөр, хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжилтэд өөр арга ашиглахыг зөвшөөрсөн уг чөлөөлөх заалт нь дээрх хууль эрхзүйн орчны эсвэл хөрөнгийн биржийн шаардлага аж ахуйн нэгжид бүхэлд нь эсвэл түүний тодорхой хэсэгт хамаатай байх хугацаанд, уг аж ахуйн нэгжийн холбогдох хэсэгт мөрдөгдөх боломжтой эсэхийг тодорхой болгох юм.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ39–ДҮ43 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

Асуулт 4- Дэлхийн дулаарлын потенциал (ДДП)-ын үнэ цэнийн талаарх хууль эрх зүйн орчин дахь чөлөөлөх нөхцөлийг мөрдөх боломж

ТБОУСЗ нь СТОУС ТБ2-ын Б21–Б22 параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, уг стандарт дахь хууль эрхзүйн орчны чөлөөлөх нөхцөлийг нэмэгдүүлэхийг зорьж байгаа.

ТБОУСЗ-ийн санал болгосноор, хэрэв хууль эрх зүйн орчин дахь эрх бүхий байгууллага эсвэл аж ахуйн нэгжийн бүртгэлтэй хөрөнгийн бирж нь СТОУС ТБ2-ын Б21–Б22-д шаардсан ДДП-ын үнэ цэнээс өөр дэлхийн дулаарлын потенциал (ДДП)-ын үнэ цэнийг аж ахуйн нэгжид бүхэлд нь эсвэл зарим хэсэгт ашиглахыг шаарддаг бол аж ахуйн нэгжийн холбогдох хэсэгт тэрхүү хууль эрх зүйн орчин дахь эрх бүхий байгууллага эсвэл хөрөнгийн биржээс шаарддаг ДДП-ын үнэ цэнэ ашиглахыг зөвшөөрөх бөгөөд энэ нь тухайн шаардлагыг мөрдөх боломжтой хугацаанд хүчинтэй байна.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ44–ДҮ49 параграфт санал болгож буй нэмэлт өөрчлөлтийн шалтгааныг тайлбарласан.

Та санал болгосон дээрх нэмэлт өөрчлөлтийг дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

Асуулт 5—Хүчин төгөлдөр болох хугацаа

Нэмэлт өөрчлөлтийн хүчин төгөлдөр болох хугацааг В1А–В1Б параграфт нэмж оруулахаар ТБОУСЗ тусгасан. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь СТОУС ТБ2-ыг мөрдөх аж ахуйн нэгжүүдийн үйл явцыг хялбаршуулж, уг Стандартыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болно хэмээн ТБОУСЗ үзэж байгаа. Иймээс ТБОУСЗ нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг хамгийн ойрын хугацаанд тогтоох, мөн дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг тэдэнд зөвшөөрөх саналыг тусгасан.

Дүгнэлтийн Үндэслэлийн ДҮ50–ДҮ51 параграфт уг саналын шалтгааныг тайлбарласан.

Нэмэлт өөрчлөлтийн хүчин төгөлдөр болох хугацаа ба дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрөх тухай дээрх саналыг та дэмжиж байна уу? Дэмжиж байвал яагаад, дэмжихгүй байвал яагаад?

Асуулт 6—Бусад санал

Энэхүү Саналын Төсөлд дурдсан төслүүдэд өгөх саналаас гадна өөр санал танд байна уу?

Санал авах эцсийн хугацаа

2025 оны 6-р сарын 27-ны дотор ирүүлсэн саналыг ТБОУСЗ авч хэлэлцэх болно.

Саналаа хэрхэн хүргүүлэх вэ

Та доорх холбоосоор нэвтэрч, судалгааг бөглөх замаар өөрийн саналаа цахим хэлбэрээр ТБОУСЗ-д ирүүлнэ үү:

Судалгаа

<https://www.ifrs.org/projects/open-for-comment/>

Эсвэл, дараах хаягаар цахим хэлбэрээр ирүүлсэн санал бүхий захидлыг ТБОУСЗ хүлээн зөвшөөрөх болно:

Online	https://www.ifrs.org/projects/open-for-comment/
Email	commentletters@ifrs.org

Санал ирүүлсэн этгээд саналаа нууцлахыг хүссэнээс бусад тохиолдолд бид ирүүлсэн саналыг нэг бүрчлэн олон нийтийн бүртгэлд хадгалж, www.ifrs.org цахим хуудаст нийтэлнэ. Нууцлах хүсэлт нь, жишээлбэл, худалдааны нууцлалтай холбоотой байх тохиолдолд ийм хүсэлтийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү бодлого болон таны хувийн мэдээллийг бид хэрхэн ашиглах тухай манай цахим хуудаснаас дэлгэрүүлэн харна уу. Хэрэв та саналаа нууцлахыг хүсэж байвал судалгааны асуулга эсвэл захидал илгээхээс өмнө commentletters@ifrs.org хаягаар бидэнтэй холбогдоно уу.

29(a)(ii), 29(a)(vi)(2) параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 29А параграфыг шинээр нэмсэн. Шинээр нэмсэн текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур нь зурж тэмдэглэсэн. Нэмэлт өөрчлөлт ороогүй боловч лавлагаа байдлаар оруулсан дэд параграфыг саарал өнгөөр будаж тодотгосон.

Гол Агуулга

...

Хэмжүүр ба зорилтот үзүүлэлтүүд

...

Уур амьсгалтай холбоотой хэмжүүр

29 Аж ахуйн нэгж нь дараах салбар хоорондын хэмжүүрийн ангилалд хамаарах мэдээллийг тодруулна:

(a) хүлэмжийн хий - аж ахуйн нэгж нь:

(i) тайлант үеийн туршид үүссэн хүлэмжийн хийн ялгаруулалтын нийт үнэмлэхүй дүнг нүүрстөрөгчийн давхар ислийн метр тонн нэгжээр (CO₂ эквивалент) илэрхийлэх (Б19-Б22 параграфыг үзнэ үү) ба доорх байдлаар ангилж тодруулна:

...

(3) *Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалт;*

(ii) эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь хүлэмжийн хийн ялгаруулалтаа бүхэлд нь эсвэл аль нэг хэсгийг хэмжихдээ өөр арга хэрэглэхийг түүнээс шаарддаг байхаас бусад тохиолдолд Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-ын дагуу хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжинэ (Б23-Б25 параграфыг үзнэ үү);

...

(vi) 29(a)(i)(3) параграфын дагуу тодруулсан ба Б32-Б57-р параграфт лавлагаа тайлбар оруулсан Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хувьд, доорх зүйлийг тодруулна:

(1) Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Үнэ Цэнийн Сүлжээ (Хамрах хүрээ 3)-ний Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2011)-д заасан, Хамрах хүрээ 3 ангилалд нийцүүлэн аж ахуйн нэгж нь Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжихэд тусган оруулсан ангиллууд;

(2) хэрэв аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хөрөнгийн менежмент, арилжааны банк эсвэл даатгалын үйл ажиллагаа хамаардаг бол

тухайн аж ахуйн нэгжийн санхүүжүүлсэн ялгаруулалт (энэ нь Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хэсэг байна) ~~эвэн түүний хөрөнгө оруулалттай холбоотой (санхүүжүүлсэн ялгаруулалт)~~-ын талаарх нэмэлт мэдээлэл (Б58-Б63-р параграфыг үзнэ үү);

...

29A Дээрх 29(a)(i)(3) параграфын шаардлагыг хангах тодруулгыг бэлдэхдээ:

- (a) Аж ахуйн нэгж Хамрах Хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжүүрт багтах зүйлсийг санхүүжүүлсэн ялгарлаар хязгаарлаж болох бөгөөд энэ нь санхүүжигчид буюу оролцогч нөгөө талд аж ахуйн нэгжийн олгосон зээл ба оруулсан хөрөнгө оруулалтад хамаарах хүлэмжийн хийн ялгаруулалт байна. “Зээл ба хөрөнгө оруулалт” гэдэгт зээл, төслийн санхүүжилт, бонд, хувьцааны хөрөнгө оруулалт, мөн зээл олгох ашиглаагүй баталгааг оруулна. Хөрөнгийн менежментийн үйл ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгжийн санхүүжүүлсэн ялгаруулалтад менежмент хийгдэж буй хөрөнгүүдэд хамаарах хүлэмжийн хийн ялгаруулалтыг оруулна. Энэхүү хязгаарлах нөхцөлийн зорилгоор, үүсмэл хэрэглүүртэй холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулгаас хасахыг аж ахуйн нэгжид зөвшөөрнө.
- (б) 29A(a) параграфын дагуу хассан, аж ахуйн нэгжийн Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалттай холбоотой үүсмэл хэрэглүүр ба санхүүгийн үйл ажиллагааны ач холбогдлыг нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдэд ойлгохуйц мэдээллийг уг аж ахуйн нэгж тодруулна. Ялангуяа тэрээр дараах мэдээллийг тодруулгад тусгана:
 - (i) Хамрах хүрээ 3, Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгыг хязгаарлах зорилгоор хассан үүсмэл хэрэглүүрийн дүн болон юуг үүсмэл хэрэглүүр гэж тодорхойлсон тайлбар;
 - (ii) тодруулгаас хассан санхүүгийн бусад үйл ажиллагааны дүн.

Хавсралт Б

Мөрдөх заавар удирдамж

Б21-Б22 параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинээр нэмсэн текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур нь зурж тэмдэглэсэн. Нэмэлт өөрчлөлт ороогүй боловч лавлагаа байдлаар оруулсан параграфыг саарал өнгөөр будаж тодотгосон.

Хүлэмжийн хий (29(a) параграф)

Хүлэмжийн хийн ялгаруулалт

...

Дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг ашиглан хүлэмжийн хийнүүдийг CO₂ эквивалентад шилжүүлэн нэгтгэх

- Б20 Аж ахуйн нэгж нь тайлант үеийн туршид үүссэн хүлэмжийн хийн ялгаруулалтын нийт үнэмлэхүй дүнг нүүрстөрөгчийн давхар ислийн метр тонн нэгжээр (CO₂ эквивалент) илэрхийлж тодруулахыг 29(a) параграфт шаарддаг. Энэхүү шаардлагыг ханган биелүүлэхийн тулд аж ахуйн нэгж нь долоон бүрэлдэхүүн хүлэмжийн хийг CO₂ эквивалент үнэ цэнэд шилжүүлэн нэгтгэнэ.
- Б21 Хэрэв аж ахуйн нэгж нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжихдээ шууд хэмжилтийг ашигладаг бол *Уур Амьсгалын Өөрчлөлтийн* Асуудлаарх Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Зөвлөлөөс 100 жилийн хугацааны хүрээнд үндэслэн хамгийн сүүлд гаргасан, тухайн тайлагналын өдөр хэрэглэх боломжтой байгаа дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг ашиглан уг аж ахуйн нэгж нь долоон бүрэлдэхүүн хүлэмжийн хийг CO₂ эквивалентад хөрвүүлэх шаардлагатай. Эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь долоон бүрэлдэхүүнт хүлэмжийн хийг CO₂ эквивалентад хөрвүүлэхдээ дэлхийн дулаарлын потенциал өөр үнэ цэнийг бүхэлд нь эсвэл хэсэгт нь хэрэглэхийг аж ахуйн нэгжээс шаарддаг байхаас бусад тохиолдолд уг аж ахуйн нэгж дээрх дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг ашиглах шаардлагыг мөрдөнө. Энэ тохиолдолд, уг эрх зүйн эсвэл биржийн шаардлага нь тус аж ахуйн нэгжийн тэрхүү хэсэгт хамааралтай байх хугацаанд уг дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг яг тэр хэсэгт ашиглахыг түүнд зөвшөөрдөг.
- Б22 Хэрэв аж ахуйн нэгж нь хүлэмжийн хийн ялгаруулалтаа тооцоолохдоо ялгаруулалтын хүчин зүйлсийг ашигладаг бол түүний үйл ажиллагааг хамгийн сайн илэрхийлэх ялгаруулалтын хүчин зүйлсийг уг аж ахуйн нэгж нь өөрийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэмжих суурь болгон ашиглана (Б29-р параграфыг үзнэ үү). Хэрэв эдгээр ялгаруулалтын хүчин зүйлс нь бүрэлдэхүүн хүлэмжийн хийнүүдийг CO₂ эквивалент үнэ цэнэд аль хэдийн хөрвүүлсэн байгаа бол *Уур Амьсгалын Өөрчлөлтийн* Асуудлаарх Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Зөвлөлөөс 100 жилийн хугацааны хүрээнд үндэслэн хамгийн сүүлд гаргасан, тухайн тайлагналын өдөр хэрэглэх боломжтой байгаа дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг ашиглан уг аж ахуйн нэгж нь ялгаруулалтын хүчин зүйлсийг дахин тооцоолох шаардлагагүй юм. Харин аж ахуйн нэгж нь CO₂ эквивалент үнэ цэнэд хөрвүүлээгүй тийм ялгаруулалтын хүчин зүйлсийг ашигладаг бол *Уур Амьсгалын Өөрчлөлтийн* Асуудлаарх Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Зөвлөлөөс 100 жилийн хугацааны хүрээнд үндэслэн хамгийн сүүлд гаргасан, тухайн тайлагналын өдөр хэрэглэх боломжтой байгаа

дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг уг аж ахуйн нэгж ашиглана. Эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь долоон бүрэлдэхүүнт хүлэмжийн хийг CO₂ эквивалентад хөрвүүлэхдээ дэлхийн дулаарлын потенциал өөр үнэ цэнийг бүхэлд нь эсвэл хэсэгт нь хэрэглэхийг аж ахуйн нэгжээс шаарддаг байхаас бусад тохиолдолд уг аж ахуйн нэгж дээрх дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг ашиглах шаардлагыг мөрдөнө. Энэ тохиолдолд, уг эрх зүйн эсвэл биржийн шаардлага нь тус аж ахуйн нэгжийн тэрхүү хэсэгт хамааралтай байх хугацаанд уг дэлхийн дулаарлын потенциал үнэ цэнийг яг тэр хэсэгт ашиглахыг түүнд зөвшөөрдөг.

Б24 болон Б28 параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинээр нэмсэн текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур нь зурж тэмдэглэсэн. Нэмэлт өөрчлөлт ороогүй боловч лавлагаа байдлаар оруулсан параграфыг саарал өнгөөр будаж тодотгосон.

Хүлэмжийн Хийн Протокол

Б23 Аж ахуйн нэгж нь Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-ын дагуу хэмжсэн, өөрийн хүлэмжийн хийн ялгаруулалтаа тодруулахыг 29(a)(ii) параграфтаар шаардсан байдаг. Эргэлзээ үүсгэхээс зайлсхийхийн тулд аж ахуйн нэгж нь энэ Стандартын шаардлагуудтай зөрчилдөхгүй байх зөвхөн тэр хэмжээнд Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-ын шаардлагуудыг дагаж мөрдөнө. Жишээлбэл, Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004) нь Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтаа тодруулахыг аж ахуйн нэгжээс шаарддаггүй боловч энэ Стандартын 29(a) параграфын дагуу аж ахуйн нэгж нь Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтаа торуулах шаардлагатай юм.

...

Б24 Эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжихдээ бүхэлд нь эсвэл хэсэгт нь өөр арга хэрэглэхийг шаарддаг байхаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж нь Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-ын дагуу хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжих шаардлагатай юм. Эрх зүйн хүрээний эрх бүхий байгууллага эсвэл тухайн аж ахуйн нэгжийн бүртгэгдсэн хөрөнгийн бирж нь хүлэмжийн хийн ялгаруулалтаа хэмжихдээ бүхэлд нь эсвэл хэсэгт нь өөр арга хэрэглэхийг шаарддаг бөгөөд эрх зүйн эсвэл биржийн ийм шаардлага нь тус аж ахуйн нэгжийн тэрхүү хэсэгт хамааралтай байх хугацаанд аж ахуйн нэгжийн тухайн хэсэг нь Хүлэмжийн Хийн Протокол: Корпорацийн Нягтлан Бодох Бүртгэл ба Тайлагналын Стандарт (2004)-ыг биш, харин уг өөр арга ашиглахыг түүнд зөвшөөрдөг.

...

Хэмжилтийн арга хандлага, орцууд болон таамаглал

...

Бусад аргууд болон хэмжилтийн арга хандлагууд

Б28 29(a)(ii), Б24–Б25, эсвэл В4(a) параграфуудыг мөрдсөнөөр, аж ахуйн нэгж нь өөр аргаар хэмжсэн, өөрийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодруулж буй тохиолдолд тухайн аж ахуйн нэгж ижил төстэй арга тус бүрийн хувьд дараах зүйлийг тодруулна:

- (a) хүлэмжийн хийн ялгаруулалтыг тодорхойлохдоо аж ахуйн нэгжийн ашигладаг зохих арга болон хэмжилтийн арга хандлага;

- (б) аж ахуйн нэгж тухайн хэмжилтийн арга ба хэмжилтийн арга хандлагыг сонгосон шалтгаан буюу шалтгаанууд, түүнчлэн уг арга хандлага нь 27-р параграф дахь тодруулгын зорилттой хэр уялдаж байгаа.

Б59, Б62(а) болон Б63(а) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Б62А–Б62В болон Б63А–Б63В параграфыг шинээр нэмсэн. Б62(а)(ii) болон Б63(а)(ii) параграфт нэмэлт өөрчлөлт ороогүй боловч Б62А(б), Б63А(б) гэж дугаарыг тус тус өөрчлөн, байршуулсан. Шинээр нэмсэн текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур нь зурж тэмдэглэсэн. Нэмэлт өөрчлөлт ороогүй боловч лавлагаа байдлаар оруулсан параграфыг саарал өнгөөр будаж тодотгосон.

Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалт

...

Санхүүжүүлсэн ялгаруулалт

...

- Б59 Аж ахуйн нэгж нь тайлант үеийн туршид үүссэн Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын нийт үнэмлэхүй дүн, үүн дотроо дээш (оруулах) урсгалын болон доош (гаргах) урсгалын ялгаруулалтаа тодруулахыг 29(а)(i)(3) параграфтаар шаардсан байдаг. Дараах нэг эсвэл хэд хэдэн санхүүгийн үйл ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгж нь ‘санхүүжүүлсэн ялгаруулалт’ (Ангилал 15-ын хүлэмжийн хийн ялгаруулалтын нэг хэсэг)-ын гэж мөн нэрлэдэг өөрийн хөрөнгө оруулалттай ~~холбоотой ялгаруулалтын~~ талаарх нэмэлт бөгөөд тусгайлсан мэдээллийг тодруулах шаардлагатай юм. Үүнд:
- (а) хөрөнгийн менежмент (Б61-р параграфыг үзнэ үү);
 - (б) арилжааны банк (Б62-р параграфыг үзнэ үү);
 - (в) даатгал (Б63-р параграфыг үзнэ үү).

Арилжааны банк

...

- Б62 Арилжааны банкны үйл ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгж нь дараах зүйлсийг тодруулна:
- (а) хөрөнгийн анги ба салбар тус бүрийн хувьд Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалт гэдгээр салган задалсан, түүний санхүүжүүлсэн ялгаруулалтын нийт үнэмлэхүй дүн. Үүнд:
 - (i) ~~[Хасагдсан] салбараар салган задлах тохиолдолд оролцогч ногоо талуудыг ангилахын тулд аж ахуйн нэгж нь тухайн тайлагналын өдрөөр бэлэн байгаа ангиллын системийн хамгийн сүүлийн хувилбарыг илэрхийлэх Дэлхийн Салбарын Ангиллын Стандарт (ДСАС)-ын 6-оронтой, салбарын түвшний кодыг ашиглана.~~
 - (ii) ~~[Хасагдсан] хөрөнгийн ангиар салган задлах тохиолдолд уг тодруулга нь эзэл, төслийн санхүүжилт, бонд, өмчийн хөрөнгө оруулалт, эзэл өлгөх ашиглаагүй баталнааг хамран тусгасан байна. Хэрэв аж ахуйн нэгж нь хөрөнгийн өөр ангиудын хувьд санхүүжүүлсэн ялгаруулалтаа тооцож,~~

~~тодруулдаг бол тэдгээр хөрөнгийн нэмэлт ангиудыг тусган оруулах нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдийг хамааралтай мэдээллээр яагаад хангана гэж үзэж буй талаарх тайлбарыг оруулна.~~

- (б) тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн толилуулгын валютаар илэрхийлсэн, хөрөнгийн анги ба салбар тус бүрд хамаарах түүний нийт эрсдэлд өртөлт. Үүнд:
- (i) санхүүжүүлсэн дүн - СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд эсвэл бусад НББНХЗЗ-ын дагуу тайлангаа бэлтгэдэг эсэхээс үл хамааран, нийт эрсдэлд өртөлтийг уг санхүүжүүлсэн дансны үнэ (хамааралтай тохиолдолд гарзын хасагдуулгыг хасахын өмнөх дүн)-ээр тооцоолно.
 - (ii) зээл олгох ашиглаагүй баталгаа – аж ахуйн нэгж нь зээл олгох баталгааны нийт дүнг уг баталгааны ашигласан хэсгээс тусад нь тодруулна.

...

Б62А Б62(а)–Б62(б) параграфын дагуу тодруулсан мэдээллийг дараах байдлаар салган задална:

- (а) салбараар- оролцогч нөгөө талуудыг ангилахдаа Б62Б параграфын дагуу салбарын ангиллын системийг ашиглана.
- (б) хөрөнгийн ангиар- уг тодруулгад зээл, төслийн санхүүжилт, бонд, өмчийн хөрөнгө оруулалт, зээл олгох ашиглаагүй баталгааг оруулж тусгана. Хэрэв аж ахуйн нэгж нь хөрөнгийн өөр ангиудын хувьд санхүүжүүлсэн ялгаруулалтаа тооцож, тодруулдаг бол тэдгээр хөрөнгийн нэмэлт ангиудыг тусган оруулах нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдийг хамааралтай мэдээллээр хангана гэж яагаад үзсэн тухайгаа тайлбарлана.

-

Б62Б Салбараар салган задлах үед, аж ахуйн нэгж нь оролцогч нөгөө талуудыг дараах салбарын ангиллын системийн аль нэгийг ашиглан дурдсан дарааллаар ангилна:

- (а) хэрэв уг аж ахуйн нэгж өөрийн аль нэг хэсгийн тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа ДСАС-ыг ашигладаг бол тухайн тайлагналын өдрөөр бэлэн байгаа ангиллын системийн хамгийн сүүлийн хувилбарыг илэрхийлэх Дэлхийн Салбарын Ангиллын Стандарт (ДСАС)-ын 6 оронтой, салбарын-түвшний код.
- (б) хэрэв (а)-г мөрдөх боломжгүй бөгөөд эрхзүйн хүрээний эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн бүртгэгдсэн хөрөнгийн биржээс тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа тэрхүү салбарын ангиллын систем ашиглахыг шаарддаг бол, уур амьсгалтай холбоотой санхүүгийн мэдээллийг тайлагнахдаа эрхзүйн хүрээний эсвэл биржийн шаардлагыг хангахын тулд уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн ашигладаг салбарын ангиллын уг систем. Хэрэв аж ахуйн нэгж нь хэд хэдэн эрхзүйн эсвэл биржийн шаардлагад нийцүүлэх шаардлагатай бөгөөд энэ зорилгоор нэгээс олон салбарын ангиллын систем ашигладаг тэдгээр ангиллын системээс нэгийг нь сонгоно.
- (в) хэрэв (а)-(б)-г мөрдөх боломжгүй бөгөөд эрхзүйн хүрээний эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн бүртгэгдсэн хөрөнгийн биржээс тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа тэрхүү салбарын ангиллын систем ашиглахыг шаарддаг бол, санхүүгийн тайлагналын зорилгоор тухайн эрхзүйн хүрээний эсвэл биржийн шаардлагыг хангахын тулд уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн ашигладаг салбарын

ангиллын систем. Хэрэв аж ахуйн нэгж нь хэд хэдэн эрхзүйн эсвэл биржийн шаардлагад нийцүүлэх шаардлагатай бөгөөд энэ зорилгоор нэгээс олон салбарын ангиллын систем ашигладаг тэдгээр ангиллын системээс нэгийг нь сонгоно.

- (г) Хэрэв (а)–(в)-д дурдсан системийг мөрдөх боломжгүй байвал, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээлэл өгөх тийм арга хэлбэрээр оролцогч нөгөө талуудыг салбараар нь ангилах боломжийг аж ахуйн нэгжид олгодог салбарын ангиллын систем.

Б62В Аж ахуйн нэгж өөрийн санхүүжүүлсэн ялгаруулалтын талаарх мэдээллийг салган задлахдаа ашигласан, салбарын ангиллын системийг тодруулна. Хэрэв аж ахуйн нэгж энэ зорилгоор ДСАС-ыг ашигладаггүй бол тэрээр салбарын ангиллын системийг сонгосон үндэслэлээ тайлбарлана.

Даатгал

...

Б63 Даатгалын салбартай холбоотой санхүүгийн үйл ажиллагаанд оролцдог аж ахуйн нэгж нь дараах зүйлсийг тодруулна:

- (а) хөрөнгийн анги ба салбар тус бүрийн хувьд Хамрах хүрээ 1, Хамрах хүрээ 2, Хамрах хүрээ 3-ын хүлэмжийн хийн ялгаруулалт гэдгээр салган задалсан, түүний санхүүжүүлсэн ялгаруулалтын нийт үнэмлэхүй дүн.
- (i) ~~[Хасагдсан] — салбараар салган задлах тохиолдолд оролцогч нөгөө талуудыг ангилахын тулд аж ахуйн нэгж нь тухайн тайлагналын өдрөөр бэлэн байгаа ангиллын системийн хамгийн сүүлийн хувилбарыг илэрхийлэх Дэлхийн Салбарын Ангиллын Стандарт (ДСАС)-ын 6-оронтой, салбарын түвшний кодыг ашиглана.~~
- (ii) ~~[Хасагдсан] хөрөнгийн ангиар салган задлах тохиолдолд уг тодруулга нь зээл, бонд, өмчийн хөрөнгө оруулалт, түүнчлэн зээл олгох ашиглаагүй баталгааг хамран тусгасан байна. Хэрэв аж ахуйн нэгж нь хөрөнгийн өөр ангиудын хувьд санхүүжүүлсэн ялгаруулалтаа тооцож, тодруулдаг бол тэдгээр хөрөнгийн нэмэлт ангиудыг тусган оруулах нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдийг хамааралтай мэдээллээр яагаад хангана гэж үзэж буй талаарх тайлбарыг оруулна.~~
- (б) тухайн аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн толилуулгын валютаар илэрхийлсэн, хөрөнгийн анги ба салбар тус бүрд хамаарах түүний нийт эрсдэлд өртөлт. Үүнд:
- (i) санхүүжүүлсэн дүн - СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд эсвэл бусад НББНХЗЗ-ын дагуу тайлангаа бэлтгэдэг эсэхээс үл хамааран, нийт эрсдэлд өртөлтийг уг санхүүжүүлсэн дансны үнэ (хамааралтай тохиолдолд гарзын хасагдуулгыг хасахын өмнөх дүн)-ээр тооцоолно.
- (ii) зээл олгох ашиглаагүй баталгаа – аж ахуйн нэгж нь зээл олгох баталгааны нийт дүнг уг баталгааны ашигласан хэсгээс тусад нь тодруулна.

Б63А Дээрх Б63(а)-Б63(б)-ийн дагуу тодруулсан мэдээллийг дараах байдлаар салган задална:

- (а) салбараар- оролцогч нөгөө талуудыг Б63Б параграфын дагуу салбарын ангиллын системийг ашиглан ангилна.

- (б) хөрөнгийн ангиар- уг тодруулгад зээл, төслийн санхүүжилт, бонд, өмчийн хөрөнгө оруулалт, зээл олгох ашиглаагүй баталгааг оруулж тусгана. Хэрэв аж ахуйн нэгж нь хөрөнгийн өөр ангиудын хувьд санхүүжүүлсэн ялгаруулалтаа тооцож, тодруулдаг бол тэдгээр хөрөнгийн нэмэлт ангиудыг тусган оруулах нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдийг хамааралтай мэдээллээр хангана гэж яагаад үзсэн тухайгаа тайлбарлана.

Б63Б Салбараар салган задлах үед, аж ахуйн нэгж нь оролцогч нөгөө талуудыг дараах салбарын ангиллын системийн аль нэгийг ашиглан дурдсан дарааллаар ангилна:

- (а) хэрэв уг аж ахуйн нэгж өөрийн аль нэг хэсгийн тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа ДСАС-ыг ашигладаг бол тухайн тайлагналын өдрөөр бэлэн байгаа ангиллын системийн хамгийн сүүлийн хувилбарыг илэрхийлэх Дэлхийн Салбарын Ангиллын Стандарт (ДСАС)-ын 6 оронтой, салбарын-түвшний код.
- (б) хэрэв (а)-г мөрдөх боломжгүй бөгөөд эрхзүйн хүрээний эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн бүртгэгдсэн хөрөнгийн биржээс тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа тэрхүү салбарын ангиллын систем ашиглахыг шаарддаг бол, уур амьсгалтай холбоотой санхүүгийн мэдээллийг тайлагнахдаа эрхзүйн хүрээний эсвэл биржийн шаардлагыг хангахын тулд уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн ашигладаг салбарын ангиллын уг систем. Хэрэв аж ахуйн нэгж нь хэд хэдэн эрхзүйн эсвэл биржийн шаардлагад нийцүүлэх шаардлагатай бөгөөд энэ зорилгоор нэгээс олон салбарын ангиллын систем ашигладаг тэдгээр ангиллын системээс нэгийг нь сонгоно.
- (в) хэрэв (а)-(б)-г мөрдөх боломжгүй бөгөөд эрхзүйн хүрээний эсвэл уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн бүртгэгдсэн хөрөнгийн биржээс тайлагналын өдрөөрх зээл олголт эсвэл хөрөнгийн оруулалтын үйл ажиллагааг ангилахдаа тэрхүү салбарын ангиллын систем ашиглахыг шаарддаг бол, санхүүгийн тайлагналын зорилгоор тухайн эрхзүйн хүрээний эсвэл биржийн шаардлагыг хангахын тулд уг аж ахуйн нэгж эсвэл түүний нэг хэсгийн ашигладаг салбарын ангиллын систем. Хэрэв аж ахуйн нэгж нь хэд хэдэн эрхзүйн эсвэл биржийн шаардлагад нийцүүлэх шаардлагатай бөгөөд энэ зорилгоор нэгээс олон салбарын ангиллын систем ашигладаг тэдгээр ангиллын системээс нэгийг нь сонгоно.
- (г) Хэрэв (а)-(в)-д дурдсан системийг мөрдөх боломжгүй байвал, нийтлэг зорилготой санхүүгийн тайлан илтгэлийн хэрэглэгчдэд ач холбогдолтой мэдээлэл өгөх тийм арга хэлбэрээр оролцогч нөгөө талуудыг салбараар нь ангилах боломжийг аж ахуйн нэгжид олгодог салбарын ангиллын систем.

Б63В Аж ахуйн нэгж өөрийн санхүүжүүлсэн ялгаруулалтын талаарх мэдээллийг салган задлахдаа ашигласан, салбарын ангиллын системийг тодруулна. Хэрэв аж ахуйн нэгж энэ зорилгоор ДСАС-ыг ашигладаггүй бол тэрээр салбарын ангиллын системийг сонгосон үндэслэлээ тайлбарлана.

Хавсралт В

Хүчин төгөлдөр болох хугацаа ба шилжилт

B1A-B1B параграфыг шинээр нэмсэн. Шинээр орсон текстийн доогуур зурж тэмдэглэсэн.

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

B1A Хүлэмжийн хийн ялгаруулалтын тодруулгад орсон нэмэлт өөрчлөлт, [... оны сар]-д гаргасан:

(a) 29(a)(ii), 29(a)(vi)(2), B21–B22, B24, B28, B59, B62(a) болон B63(a) параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан;

(б) 29A, B62A–B62B, B63A–B63B болон B1A–B1B параграфыг шинээр нэмсэн.

B1B Аж ахуйн нэгж нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг [... оны-р сарын ...]-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант жилийн хувьд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв аж ахуйн нэгж нь эдгээр нэмэлт өөрчлөлтийг дурдсан хугацаанаас өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулна.

ТНББСЗ-ийн Стандартуудад дагалдан орж байгаа нэмэлт өөрчлөлтүүд

СТОУС ТБ2-т оруулах нэмэлт өөрчлөлтүүд бүхий параграфыг ТНББСЗ-ийн Стандартуудын лавлагаа байдлаар Хүснэгт А1-т харууллаа. СТОУС ТБ2-т хамаарах эдгээр лавлагааг ТНББСЗ-ийн Стандартын техникийн протоколд тусгасан байгаа. ТБОУСЗ нь СТОУС ТБ2-ын нэмэлт өөрчлөлтүүдтэй эдгээр лавлагааг нийцүүлэх үүднээс ТНББСЗ-ийн стандартуудад холбогдох өөрчлөлтийг хийх юм.

Хүснэгт А1- ТНББСЗ-ийн Стандартуудад дагалдан орж байгаа нэмэлт өөрчлөлтүүд

Нэмэлт өөрчлөлтийн төрөл	ТНББСЗ-ийн Стандартууд	Тодруулгын сэдэв
ТНББСЗ -ийн Стандартуудад багтсан техникийн протокол дахь СТОУС ТБ2-ын тодорхой параграфуудад хийсэн лавлагааг шинэчлэн засварлах	Хөрөнгийн менежмент ба кастодийн үйл ажиллагаа	Санхүүжүүлсэн ялгаруулалт
	Арилжааны банкууд	Санхүүжүүлсэн ялгаруулалт
	Даатгал	Санхүүжүүлсэн ялгаруулалт

2025 оны 4-р сард гаргасан Хүлэмжийн Хийн Ялгаруулалтын Тодруулгад Оруулах Нэмэлт Өөрчлөлтийн Саналын Төсөл-ийг ТБОУСЗ-өөс баталсан нь

Тогтвортой Байдлын Олон Улсын Стандартын Зөвлөлийн 14 гишүүн бүгд *Хүлэмжийн Хийн Ялгаруулалтын Тодруулгад Оруулах Нэмэлт Өөрчлөлтийн Саналын Төсөл-ийг* гаргахыг зөвшөөрсөн.

Эммануэл Фабер

Дарга

Жиндонг Хуа

Дэд дарга

Сюзан Ллойд

Дэд дарга

Ричард Баркер

Женни Бофингер-Шустер

Верити Чегар

Жеффри Хэйлс

Майкл Жанци

Хироши Комори

Бинг Ленг

Ндиди Нноли-Эдозиен

Тэ Янг Паик

Вероника Поунчева

Элизабет Сигер



IFRS[®]
Foundation

Columbus Building
7 Westferry Circus
Canary Wharf
London E14 4HD, UK

Tel **+44 (0) 20 7246 6410**
Email **customerservices@ifrs.org**

ifrs.org

The IFRS Foundation has trade marks registered around the world, including 'FSA[®]', 'IASB[®]', 'IFRS[®]', 'International Financial Reporting Standards[®]', 'ISSB[®]', and 'SASB[®]'. For a full list of our registered trade marks, visit www.ifrs.org.